



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/64

Сүхбаатар сум

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “л”, 29.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Улсын Их хурлын 2011 оны “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай” 22 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргаас Улаан загалмайн хороотой байгуулсан хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшиг болон гэнэтийн осол галын аюулд өртсөн иргэдэд яаралтай нөхөн сэргээх тусламж үйлчилгээний бараа, материалын нөөцийг аймгийн Засаг дарга болон Улаан загалмайн хорооны хамтран ажиллах гэрээний дагуу аймгийн Улаан загалмайн хороонд бүрдүүлсүгэй.

2.Нөөцийг бүрдүүлэх, бараа материал худалдан авахад шаардагдах 5.000.000 /таван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох тайланг улирал бүр гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг аймгийн Улаан загалмайн хорооны дарга /Ц.Ганчулуун/-д үүрэг болгосугай.

4.Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801184